

Батлав:  ЭХС-ийн захирал доктор, проф. Ч.Мангалжалав

**ЭХС-ийн нэрэмжит “Цахилгаан техникийн үндэс” хичээлийн УЛСЫН нээлттэй
олимпиадын удирдамж**

Нэг. Зорилго

“Цахилгаан техникийн үндэс” хичээлийн сургалтанд ШУТИС-ийн салбар сургуулиудын оюутнууд хамрагддаг бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улиралд ЭХС, ГУУС, ҮТС, ХШУС, МехТС-ийн 510 гаруй оюутнууд цахимаар уг хичээлийг үзэж байна. ЭХС-ийн нэрэмжит энэхүү олимпиад нь жил бүр уламжлал болон амжилттай явагддаг бөгөөд тус олимпиадын хамрах хүрээг өргөтгөн “Цахилгаан техникийн үндэс”, “Цахилгаан техник” хичээлийг судалдаг бүх их дээд сургуулиудыг урин оролцуулж тус олимпиадыг улсын болгон өргөжүүлэн зохион байгуулж ирсэн билээ. Тус олимпиадад ШУТИС-ийн салбар сургуулиудаас гадна дээрх хичээлийг судалдаг МУИС, ХААИС, “Шинэ Монгол” технологийн дээд сургууль (ТДС), Үндэсний Техникийн Их Сургууль (ҮТИС), “Их засаг” Олон Улсын Их Сургууль (ОУИС), Герман Монголын Хамтарсан Технологийн Их Сургууль (GMIT), Техник Технологийн Их Сургууль (ИЕТ)-ийн цахилгааны бус мэргэжлийн инженерийн чиглэлээр суралцагч оюутнууд, удирдагч багшийн хамт амжилттай оролцож ирлээ. Инженерийн чиглэлээр суралцагч оюутан нь цахилгаан техникийн мэдлэггүйгээр цахилгаан болон электрон төхөөрөмжтэй ажиллах боломжгүй тул тэдний танхимын хичээлээр олсон мэдлэгийг өргөтгөх, бататгах, оюутны сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх, оюуны чадавхыг хөгжүүлэхэд тус олимпиадын зорилго оршино. Түүнчлэн оролцогч сургуулийн мэргэжлийн багш нар туршлага солилцож, “Цахилгаан техникийн үндэс” хичээлийн үр өгөөж, агуулгыг өргөтгөн сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Хоёр. Олимпиад явуулах журам

Олимпиадыг хоёр үе шаттайгаар зохион байгуулж явуулна..

1-р шат. 2021 оны 4-р сарын 15-наас 23-ны хооронд тухайн хичээлийг заадаг багш нар тус тусын сургууль дээр хариуцан явуулна. Олимпиадад “Цахилгаан техникийн үндэс” хичээлийн стандартад тусгагдсан сэдвүүд хамрагдана. Эхний шатны шалгалтанд дараах сэдвүүд хамрагдана.

Үүнд:

- | | |
|---|---------|
| 1. Тогтмол гүйдлийн цахилгаан хэлхээ | 30 оноо |
| 2. Нэг фазын хувьсах гүйдлийн цахилгаан хэлхээ | 30 оноо |
| 3. Гурван фазын хувьсах гүйдлийн цахилгаан хэлхээ | 20 оноо |
| 4. Трансформатор | 10 оноо |
| 5. Тогтмол гүйдлийн цахилгаан машин | 10 оноо |

Эхний шатанд оюутан нийт дүнгээр 100 оноо авах ба үүнээс 60-аас дээш оноо авсан оюутнууд хоёрдугаар шатны шалгаруулалтанд оролцоно. Шалгалтыг цахимаар зохион байгуулах ба дээрх сэдвийн хүрээнд бодлогоор болон тестийн хэлбэрээр явагдана.

2-р шат. Эхний шатнаас шалгарсан оюутнууд хоёрдугаар шатны шалгаруулалтанд оролцоно. Олимпиад 05-р сарын 13-ны 10 цагт (Teams программын “Цахилгаан техникийн үндэс” хичээлийн НЭЭЛТГЭЙ олимпиад-2021 группын Channel өрөөнд) болно. Энэ шатны шалгаруулалтанд оюутнууд дараах сэдвүүдээр оролцох ба өгөгдөх бодлогууд, асуултууд нь сэтгэн бодох, харьцуулан жиших хувилбараар зохиогдсон байна.

Үүнд:

- | | |
|--|---------|
| 1. Тогтмол гүйдлийн цахилгаан хэлхээ | 25 оноо |
| 2. Нэг фазын хувьсах гүйдлийн цахилгаан хэлхээ | 30 оноо |
| 3. Гурван фазын хувьсах гүйдлийн цахилгаан хэлхээ | 25 оноо |
| 4. Симуляци программ ашиглан тооцоо болон хэмжилт хийх | 20 оноо |

Гурав. Шалгаруулах журам

Олимпиадад оролцсон оюутнуудаас 5 байр эзлүүлэх ба нэгдүгээр байр 1, хоёрдугаар байр 2, гуравдугаар байр 2 байна. Байр эзлүүлэхдээ оноогоор дүгнээд эхний 5 оюутанг сонгон шалгаруулна. Оноо ижил тохиолдолд эхний шалгаруулалтын оноог харгалзан үзнэ. Мөн тусгай байранд 5 оюутанг шалгаруулна.

| | |
|-------------------------|-------------------------------------|
| 1-р байр нэг | 500000 төг, 1-р байрын өргөмжлөл |
| 2-р байр хоёр тус бүр | 300000 төг, 2-р байрын өргөмжлөл |
| 3-р байр хоёр тус бүр | 200000 төг, 3-р байрын өргөмжлөл |
| Тусгай байр тав тус бүр | 100000 төг, Тусгай байрын өргөмжлөл |

Багийн дүнгээр байр эзлүүлэн 1-р байранд орсон багийн сургуульд нь Шилжин явах цом гардуулна.

Дөрөв. Олимпиадад оролцох

1. Тухайн их дээд сургуулийн Цахилгааны инженерийн бус мэргэжлийн ангиудын “Цахилгаан техникийн үндэс”, “Цахилгаан техник” хичээлийг 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улиралд судалж байгаа оюутнууд оролцох ба 2-р шатны шалгаруулалтанд 5 оюутан 1 багшийн бүрэлдэхүүнтэйгээр баг болон оролцоно. Оролцогч оюутан нь тухайн хичээлийг энэ хаврын улиралд үзэж байгаа болохыг удирдагч багш баталгаажуулан мэдүүлэгт хавсаргана.
2. Багийн мэдүүлгийг 2021 оны 04 сарын 22-ны дотор ШУТИС-ийн олимпиадын комиссын гишүүн Х.Сарангэрэлд sarangerelkhayankhyarvaa2020@gmail.com, sarangerel@must.edu.mn /99087723/ хаягаар илгээнэ.
3. Мэдүүлэгт бүртгэгдсэн оролцогч оюутан нь Техникийн зөвлөгөөнөөр өгсөн журмын дагуу техник хангамжийн бэлтгэлээ хангана.
4. Олимпиадад оролцох их дээд сургуулийн багш нар сэдвийн хүрээнд 2-3 бодлого бэлтгэх ба олимпиадын 2-р шатны шалгаруулалтын бодлого сонголт, хяналт, засалт шалгаруулалтанд оролцоно. Багш олимпиадын бодлого сонголтонд оролцохдоо комисстой холбогдон мэдээлэл авах ба эсвэл zagdaal@gmail.com, zagdkhorol@must.edu.mn /99085773/ хаягаар авна.

Тав. Оюутан юу бэлдэх вэ?

1. Лекц ба семинарын хичээлээр үзсэн сэдвүүдийн дагуу бодлого бодож чадах
2. Лекцийн хичээлээр үзсэн сэдвүүдийн онолын хэсгийг тайлбарлаж чадах
3. Техникийн зөвлөлгөөнд өгсөн журмын дагуу техник хангамжийн бэлтгэлээ хангана. (камер, зөөврийн болон суурин компьютер, чихэвч, тооны машин, микрофон)
4. Оюутан бүр gmail хаягтай байх. Teams программ ашиглах чадвартай байх.

Олимпиадыг зохион байгуулагч: ЭХС-ийн Цахилгаан техникийн салбар